



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 01 сарын 11 өдөр

Дугаар Б/10

Хэрлэн сум

**С.Лхагвацэрэнд сахилгын  
шийтгэл ногдуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.1, 48 дүгээр зүйлийн 48.3, 37 дугаар зүйлийн 37.1.16 дахь заалт, Монгол Улсын Сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 36/32 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл оногдуулах, түүнд гомдол гаргах журам”-ын 1.4, 1.5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Ажлын цагийг үр бүтээлтэй ашиглаагүй, өгсөн үүрэг даалгаврыг хангалтгүй биелүүлсэн Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн Сүхбаатарын Лхагвацэрэнд сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2.Албан үүргээ холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд биелүүлж, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж ажиллахыг С.Лхагвацэрэнд үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Ж.Гантулга)-т даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР